XII ангийн үндэсний бичгийн дасгал ажил

**Бие даан суралцах ажлын дэвтэр (ажлын хуудас)**

**Сэдэв:** Аялгуу сайхан монгол хэл эхийг уншиж, зарим үгийн үндсийг зөв бичих

| 1 | Сурагчийн овог нэр ………………………………… | Эхэлсэн.....он....сар....өдөр....цаг...<br>Дууссан......он...сар.....өдөр...цаг... |
|---|---|---|

**Агуулгын товч тайлбар:**

- Эхийг унших явцдаа зарим үгийг үндэсний бичгээр хэрхэн бичиж буйг ажиглаарай.
- “Аран” хэмээх үг нь ард гэсэн үгийн ганц тоо, эгэл харц хүн.
- Монгол хэлэнд адилтгах, харьцуулах, жиших утгатай “ᠦᠯᠢ -”(үли-) гэсэн үг бий. Үйлээс нэр үг бүтээх “- ᠭᠡᠷ” дагар залгавал “ᠦᠯᠢᠭᠡᠷ” (үлгэр) гэсэн үг бүтнэ. Орчлонгийн элдэв явдлыг жишээлэн өгүүлсэн зохиолыг “үлгэр” гэдэг. Мөн хувцас дээл хийх эх загварыг “үлгэр” гэж хэлдэг нь тус “ᠦᠯᠢ -” (үли-) гэсэн язгуурын утга билээ.

**Алхам 1.** Эхийг кирилл бичигт буулгаж, өнгөөр ялгасан үгсийг хэрхэн бичиж буйг нүдлэн тогтоогоорой.



……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

**Алхам 3.** Загварыг ажиглаад өгөгдсөн үгсийг үндэсний бичгээр бичээрэй.




нийтлэг, урлаг, борлог, тавлаг, тухлаг, харлаг, модлог, чийглэг

**Алхам 3.** Өгөх, оршихын тийн ялгал " ᠳᠤ · ᠲᠤ "-ийн эртний "ᠳᠠ" хувилбар нь цагийн утгат зарим үгийн үндсэнд шингэж хамт бичигдэх болсон дараах үгсийг үндэсний бичгээр бичээрэй.

мөнхөд, ашид, хэзээд, өнөд, үүрд, үргэлжид, эгнэгт, ямагт

**Алхам 3.** "Аялгуу сайхан монгол хэл" эхийн үргэлжлэлийг үндэсний бичгээр бичнэ үү. https://mongoltoli.mn/ линкээр орж толь бичиг ашиглаарай.

... Үүний жишээнд ерөөл магтаал, үлгэр туульс, зүй цэцэн үгс оньсого таавар зэрэг оюун санаанд бүрэлдэж, үеэс үед ам дамжин уламжилсан олон бүтээл бүтээлийг дурдаж болно. Энэхүү аман соёлыг монголчууд төгс боловсруулсны хүчээр ном бичгийн хэл хөгжих суурь баттай тавигдсан юм.

**Сэдэв:** Эхийг уншиж, зарим үгийн бичлэгийн онцлогийг таних

| 2 | Сурагчийн овог нэр<br>………………………………… | Эхэлсэн.....он....сар....өдөр....цаг...<br>Дууссан......он...сар.....өдөр...цаг... |
|---|---|---|

**Агуулгын товч тайлбар:**

- Монгол бичгийн хэлнээ зарим -су, -сү төгсгөлтэй үг өсөж төлжих, ургахтай холбоотой утгыг агуулдаг. Жишээ нь: үс - үсү, хялгас - хилгасу, ноос-ноосу (арьснаас ургах) сормуус- сормуусу (зовхиноос ургах) өвс-эбэсү (хөрснөөс ургах), хумс-химусу (хуруунаас ургах) өргөс - өргэсү, төмс - төмүсү гэх мэт. Мөн мод ургамлын нэрс болон шингэн зүйлсийг гол төлөв -су, -сү төгсгөлөөр бичдэг.
- "Цус (чису)" хэмээх үгийн "чи-" язгуур "улаан" гэсэн утгатай. Энэ "улаан" хэмээх утгатай "чи-" язгуураас үүссэн үг хэмээвээс, царай-ЧИрай, час-ЧИс улаан гэдгийн ЧИс зэрэг юм.

**Алхам 1.** Эхийг кирилл бичигт буулгаж, тодруулсан үгсийг хэрхэн бичиж буйг нүдлээрэй.

[illegible]

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………………

**Алхам 2.** Доорх дуудлага ойролцоо бичлэг ондоо үгсийг нүдэлж, 3-аас доошгүй холбоо үг үүсгэн бичээрэй. **бэлгэ** /тэмдэг/ **бэлэг** /дурсгал/ **билиг** /оюун/

ᠪᠡᠯᠭᠡ ᠪᠡᠯᠡᠭ ᠪᠢᠯᠢᠭ

**Алхам 3.** Шингэн зүйл болон мод, жимсний нэрийг үндэсний бичгээр бичээрэй.

| Ус | Нарс | Цас | Нэрс | Хөлс | Монос | Аньс | Нулимс |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |

**Алхам 4.** Эхийг үндэсний бичгээр бичээрэй.

Хүндлэн зочлох ёс

Манай өвөг дээдсийн онцгой сайхан чанар бол алс холын зочин гийчнийг дээд зэргээр хүндэтгэн дайлдаг зочломтгой ёс бөгөөд үүгээрээ ихэд алдаршсан билээ. Монголчууд эртнээс нааш “манай гэр бүл танай гэр, танай гэр бүл манай гэр” хэмээн үзэж ирсэн тул зочноо сайхан цай, амтат хоол идээ цагаа айраг дарс аль байдгаараа хүндэтгэн зочилсоор иржээ.

**Сэдэв:** Эхийг монгол бичигт хөрвүүлж, дагавар, нөхцөлийг үгийн үндсэнд зөв залган бичих

| | | |
|---|---|---|
| 3 | Сурагчийн овог нэр ………………………………… | Эхэлсэн…..он….сар….өдөр….цаг…<br>Дууссан……он…сар…..өдөр…цаг… |

**Агуулгын товч тайлбар:**

- "-д – ᠳᠤ" дагаврыг нэр үгийн язгуур, үндсэнд залгаж, голдуу орон байр, зүг чигийг заасан нэр үг бүтээнэ.
- Монгол хэл залгамал бүтэц хэл бөгөөд үгийн үндсийг зүй тогтлын дагуу бичиж, залгавар бүтээврийг хэрхэн бичиж буйг нүдлэн тогтоох нь чухал.

**Алхам 1.** Орны нэрсийг үндэсний бичгээр бичээрэй.

дээд, доод, цаад, наад, өрнөд, дорнод, өмнөд, умард, гадаад, дотоод

**Алхам 2.** "Нэр үндэс+нэрээс үйл үг бүтээх дагавар+хэвийн дагавар+ цагаар төгсгөх нөхцөл" загварт тохирох 8-аас доошгүй үг олж бичнэ үү. Жишээ нь: Эв+л+лд+нэ

ᠡᠪᠯᠡᠯᠳᠦᠨ᠎ᠡ

**Алхам 4.** Үндэсний бичгээр бичнэ үү. (Чой. Лувсанжавын "Хадмал толь"-ийг ашиглаарай)

Авиа гаргах эрхтнийг уг үндсээр нь өөрчлөөгүй цагт ямар ч угсаатан дуу авиагаараа танигдах билээ. Өөрөөр хэлбэл хүний дуу хоолой нь гарын өндөгний хээ хуар шиг давтагдашгүй өвөрмөц шинж тэмдгийг агуулсан онцгой үзэгдэл юм. Л.Түдэв

**Сэдэв:** Зарим үгийн бичлэгийн онцлогийг таних

| 4 | Сурагчийн овог нэр<br>………………………………… | Эхэлсэн…..он….сар….өдөр….цаг…<br>Дууссан……он…сар…..өдөр…цаг… |
|---|---|---|

**Агуулгын товч тайлбар:**

- Монгол бичгийн хэлнээ "ри-" төгсгөлт дийлэнх үйл үг эргэлдэх-тойрох, эргэх-буцах утгаараа дам холбогддог билээ. Жишээ нь: тойр-, төөр-, өнхөр-, бөмбөр-, хөмөр-, хөлбөр-(холбир-,хэлбэр-), эр, тэмтэр-, ухар- гэх мэт. Мөн цагариглах утга бүхий зарим үйл үг "атир-, хатир-, тэвэр-" зэрэг үгс монгол бичигт "ри-" хэлбэрээр төгсөнө.
- Тагнайшсан “р” гийгүүлэгчийн өмнөх урт эгшигийг орчин цагийн монгол хэлнээ хос эгшгээр дуудах болсон цөөн хэдэн үйл үг бий.
- Нэг үетэй “гар -, хүр-, сур-, чир-” зэрэг үгэнд (-ч, -чээ) нөхцөлийг залган бичдэг. Энэ нь тухайн үйл үг монгол бичигт дэвсгэр үсгээр төгсөж буйг илэрхийлнэ.
- Нэг үетэй богино эгшгээр эхэлсэн “р”-ээр төгссөн үйл үг монгол бичигт дэвсгэр үсгээр төгсдөггүй.

**Алхам 1.** Эхийг кирилл бичигт буулгаарай.



………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………………………………

**Алхам 2.** Дараах үйл үгсийг үндэсний бичгээр бичнэ үү.

тойр-, тээр-, өнхөр-, бөмбөр-, хөмөр-, хөлбөр-, дайр-, хайр-, тайр-, холбир-

**Алхам 3.** Үйл *үгсийг үндэсний бичгээр бичнэ үү.*

хүр-, ир-, хар-, ор-, нур-, ур-, гар-, эр-, чир-, зар-

**Алхам 4.** "Нэр язгуур + үйл үг бүтээх дагавар+ цагаар төгсгөх нөхцөл" загварт тохирох бүлэг үгийг олоод, үндэсний бичгээр бичээрэй.

А. униартав, цантаж, нийтлэв, зөвдөв

Б. нээлгэв, баярлаарай, завчиллаа, чиглэе

В. зуншлаа, жолооджээ, батлав, өрөмтөнө

Г. цайрлаа, нэгдэв, бодогдоно, хүрэнжээ

**Алхам 5.** Үндэсний бичгээр бичээрэй.

Хуучир

Хуучир хөгжим нь монгол ардын үндэсний хөгжмийн нэгэн төрөл зүйл юм. Эртний энэ хуур нэг чавхдастай байгаад сүүлдээ хосоор хөглөдөг дөрвөн чавхдастай болсон. Монгол хуучир угалзтай, зургаан талсттай, модон бортоготой, иш нь мөн угалзтай, дөрвөн чихтэй морин толгойтой байжээ.

**Сэдэв:** Зарим үгийг зүй тогтлын дагуу зөв бичих

| 5 | Сурагчийн овог нэр ...................................... | Эхэлсэн.....он....сар....өдөр....цаг...<br>Дууссан......он...сар.....өдөр...цаг... |
|---|---|---|

**Агуулгын товч тайлбар:**

- Монгол бичгийн хэлнээ Н+Г, Н+Х, Н+Ш, Г+Н гийгүүлэгчийн нийлц үүсэхэд гол төлөв Г,Х, Ш, Н гийгүүлэгчийн өмнө их инхлэг бичнэ.
- Кирилл бичгийн хэлнээ "ж,ч,ш"-ийн дараа а, о, у, ө, ү эгшигтэй бичих үгсийг монгол бичигт тэргүүн үедээ гол төлөв " жи, чи, ши " хэлбэрээр бичнэ.

**Алхам 1.** Зүй тогтлын дагуу дараах үгсийг үндэсний бичгээр бичээрэй.

анх, цонх, янгир, онгоц, магнаг, тагнай,тоншуул,банш

**Алхам 2.** Их инхлэгтэй бичигдэх харь хэлний үгсийг үндэсний бичгээр бичээрэй.

банз, вандуй, ванлий, данс, дэнс, гуанз, гүнж, жанжин, жинс, янз

**Алхам 3.** Доорх үгсийг зүй тогтлын дагуу үндэсний бичгээр бичнэ үү.

жавар, жороо, журам, чанга, чухал, чөдөр, шавар, шөрмөс, шүд, шүүдэр

**Алхам 4.** Үндэсний бичгээр бичээрэй.

Монгол урианхайн туульчид тууль хайлахын өмнө "Алтайн магтаал" хайлдаг уламжлалтай. Алтайн магтаалыг хайлахад уул, усны эзэн савдаг баясан цэнгэж зуд, турхан, ган гачиг, өвчин зовлонгүй энх тунх аж төрдөг хэмээн үздэг.

6

Сурагчийн овог нэр
……………………………………

Эхэлсэн.....он....сар....өдөр....цаг...
Дууссан......он...сар.....өдөр...цаг...

**Агуулгын товч тайлбар:**

- Монгол бичгийн хэлнээ тухайн үйл үг дэвсгэрээр төгсөх, үл төгсөж буйг тогтоох арга нэг мөр болоогүй ч "с" дэвсгэрээр төгсөх үйл үгийг шалгуураар мэдэх боломжтой юм. С гийгүүлэгчээр төгссөн эсэхийг бусдаар үйлдүүлэх хэвийн -га(-ха), -гэ(-хэ) дагаврыг залгаж мэднэ. Д, С гийгүүлэгчийн араас -га, -гэ дагаврыг залгахад (-ха, -хэ) болон ондоошдог билээ.
- Үйл үг бүтээх “-ги, – ᠭᠢ ” дагаврыг авиа дуурайх язгуур үгэнд шууд залгаж бичнэ.

**Алхам 1.** Үйл үгсийг үндэсний бичгээр бичээрэй.

ороо-, улээ-, тэжээ-, гүйцээ-, тараа-, инээ-, мишээ-, дусаа-, тураа-, хүлээ-

**Алхам 2.** Үйл үгсийг зүй тогтлын дагуу үндэсний бичгээр бичээрэй.

хийс-, урс-, зас-, бас-, нойрс- , нис-, хэс-, үүрс-, үүс-, хас-

**Алхам 3.** Холбоо үгсийг үндэсний бичгээр бичээрэй.

адуу тургих, болжмор жиргэх, гол харгих, цай даргих, ус цалгих, хүүхэд шуугих